



I-VI/2022


Тархаасан: 2022 оны 8 дугаар сарын 11



Мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлого өмнөх оны мөн үеэс 14.0 хувиар өслөө

Улсын хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2022 оны эхний хагас жилд 854.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 105.1 (14.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ОРЛОГО, улирлаар, тэрбум төгрөг



Энэхүү өсөлтөд утасгүй холбооны үйл ажиллагааны орлого 62.0 (14.3%) тэрбум төгрөг, утсан холбооны орлого 26.0 (28.6%) тэрбум төгрөг, өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагааны орлого 14.1 (14.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 1. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн 2 дугаар улирлын эцэст

Үзүүлэлт	2020 IV-VI	2021 IV-VI	2022* IV-VI
Суурин утасны цэг, мянган ширхэг	308.5	309.8	340.6
Үүрэн утас идэвхтэй хэрэглэгчид (давхардсан тоогоор), мянган хүн	4 422.5	4 487.0	4 674.8
Кабелийн телевизийн идэвхтэй хэрэглэгчид, мянган хэрэглэгч	900.7	943.1	975.7

Суурин утасны цэгийн тоо 2022 оны 2 дугаар улирлын эцэст 340.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 30.8 (9.9%) мянган цэгээр нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Улаанбаатар хотын суурин утасны цэг 27.8 (10.9%) мянгаар өссөн нь нөлөөлсөн байна.

Кабелийн телевиз хэрэглэгчид 2022 оны 2 дугаар улирлын эцэст 975.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 32.7 (3.5%) мянган хэрэглэгчээр өссөн байна. Кабелийн телевиз хэрэглэгчид өсөхөд Улаанбаатар хотод 6.5 (1.3%) мянга, Дорноговь аймагт 2.5 (11.1%) мянга, Ховд аймагт 2.3 (12.4%) мянга, Дархан-Уул аймагт 2.0 (8.0%) мянга, Хөвсгөл аймагт 1.9 (5.9%) мянган хэрэглэгчдээр тус тус өссөн нь нөлөөлөв.

Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид 2022 оны 2 дугаар улирлын эцэст 4.7 (давхардсан тоо) сая болж, өмнөх оны мөн үеэс 187.8 (4.2%) мянган хэрэглэгчээр өссөн байна. Энэхүү өсөлтөд Өмнөговь аймгийн хэрэглэгчид 12.8 хувиар, Улаанбаатар хотын хэрэглэгчид 9.1 хувиар, Дундговь аймгийн хэрэглэгчид 2.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.

Интернэт хэрэглэгчдийн тоо 2022 оны 2 дугаар улирлын эцэст 4.1 сая болж, өмнөх оны мөн үеэс 136.6 (3.4%) мянган хэрэглэгчээр өссөн байна. Энэхүү өсөлтөд үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчид 99.8 (2.5%) мянга, гэрээт интернэт хэрэглэгчид 36.8 (10.7%) мянгаар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Нийт шуудан, илгээмжийн хэмжээ 2022 оны эхний хагас жилд 2.8 сая ширхэг болж, өмнөх оны мөн үеэс 234.2 (7.8%) мянган ширхгээр буурсан байна. Энэхүү бууралтад дотоодын шуудан, илгээмж 11.6 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Шуудангийн үйлчилгээний салбар 2022 оны эхний хагас жилд 521.9 мянган ширхэг бичиг захидал, 95.2 мянган ширхэг боодол, 270.0 мянган ширхэг илгээлт, 75.3 мянган ширхэг буухиа, 423.0 мянган ширхэг бизнес захидал, 98.6 мянган ширхэг гибрид шуудан, 31.1 мянган ширхэг цахим худалдааны илгээмж, 1.3 сая ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэжээ.

ХҮСНЭГТ 2. ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, төрлөөр

Шуудан илгээмжийн урсгал	Бүгд		Дотоодын шуудан		Улс хоорондын гарах		Улс хоорондын орох	
	2021 I-VI	2022* I-VI	2021 I-VI	2022* I-VI	2021 I-VI	2022* I-VI	2021 I-VI	2022* I-VI
	мянган ширхэг							
Нийт шуудан, илгээмж	3 018.2	2 784.0	2 828.0	2 501.0	42.1	51.4	148.1	231.6
Бичиг захидал	496.0	521.9	453.3	461.0	9.0	15.6	33.7	45.3
Боодол	152.8	95.2	117.6	44.6	3.4	6.5	31.8	44.1
Илгээлт	251.8	270.0	187.5	123.3	17.2	22.2	47.1	124.5
Буухиа	107.0	75.3	59.0	50.5	12.5	7.1	35.5	17.7
Бизнес захидал	341.7	423.0	341.7	423.0	-	-	-	-
Гибрид шуудан	87.6	98.6	87.6	98.6	-	-	-	-
Цахим худалдааны илгээмж	11.5	31.1	11.5	31.1	-	-	-	-
Хэвлэл	1 569.8	1 268.9	1 569.8	1 268.9	-	-	-	-

Ойлголт, тодорхойлолт:

Суурин телефон цэг гэж нийтийн телефон сүлжээнд хэрэглэгчийн шугамаар телефон станц дээр порт эзлэн зориулалтын төхөөрөмжөөр холбогдсон эцсийн хэрэглэгчийг ойлгоно.

Сансрын холбооны хэрэглэгчид гэж сансрын хиймэл дагуул ашиглан холбогдож буй холбооны хэрэглэгчийг ойлгоно.

Интернэтийн байнгын хэрэглэгчид гэж сар бүр тодорхой хэмжээний төлбөр төлж интернэтийг тогтмол хэрэглэдэг хэрэглэгчийг ойлгоно.

Гибрид шуудан гэж хэрэглэгчээс мэдээллийг файл хэлбэрээр хүлээн авч, хэвлэн дугтуйлан битүүмжилж хаягт эзэнд нь хүргэх шуудангийн илгээмж юм.

Боодол гэж тодорхой этгээдэд хаягласан, эд зүйлс агуулсан битүүмжлэгдсэн шуудангийн илгээмжийг ойлгоно.

Илгээлт гэж боодлоос овор хэмжээгээрээ том шуудангийн илгээмж юм.



Эх үүсвэр:

ҮСХ, холбооны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн улирлын мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 11 дүгээр сарын 12

Эдийн засгийн статистикийн газрын

дарга А.Дэмбэрэл

Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын

Мөнгө, санхүү, үйлчилгээний статистикийн

хэлтсийн статистикч М.Батхишиг

Утас: (976-51)-264797

